



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 368

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорноговь-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9 нэрийн нийт 302,689,943.00 (гурван зуун хоёр сая зургаан зуун наян есөн мянга есөн зуун дөчин гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Дорноговь-АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Эрэвгийлхам, гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



000730

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 07
дугаар сарын 06-ний өдрийн 368 дугаар
тогтоолын хавсралт

**"ДОРНОГОВЬ-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	XCMG WZ3025 маркийн 39-97 ДО улсын дугаартай, авто ачигч, Арлын дугаар 00804017	2008/2008	57,584,167.00	2,000,000.00
2	KIA маркийн 78-91 ДГО улсын дугаартай, ачааны автомашин, Арлын дугаар 3HDP3363K921569	2009/2009	26,798,444.00	1,000,000.00
3	SHANHAI маркийн 66-93 УН улсын дугаартай, экскаватор, Арлын дугаар LG10131099	2014/2014	25,000,000.00	500,000.00
4	SHANHAI маркийн 66-92 УН улсын дугаартай, экскаватор, Арлын дугаар LG10131097	2014/2014	25,000,000.00	500,000.00
5	Индүү WZ XCMG YZ12JC маркийн 37-37 ДО улсын дугаартай, Арлын дугаар 3120090052	2009/2009	39,456,916.00	1,500,000.00
6	Автосамосвал DONGFENG маркийн 51-61 ДГА улсын дугаартай, Арлын дугаар LGAWAHAN096604004	2009/2009	34,425,208.00	1,000,000.00
7	Автосамосвал DONGFENG маркийн 51-91 ДГА улсын дугаартай, Арлын дугаар LGAWAHAN696604088	2009/2009	34,425,208.00	1,000,000.00
8	Индүү Luoyang LTC203P маркийн 66-64 УН улсын дугаартай, Арлын дугаар 12400	2014/2014	30,000,000.00	500,000.00
9	Индүү Luoyang LTC203P маркийн 66-65 УН улсын дугаартай, Арлын дугаар 12488	2014/2014	30,000,000.00	500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		302,689,943.00 (гурван зуун хоёр сая зургаан зуун наян есөн мянга есөн зуун дөчин гурван)	8,500,000.00 (найман сая таван зуун мянга)